

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2021 оны 11 дугаар сарын 04 өдөр

№ А.Г.Г. 01/5018 Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлд заасныг удирдлага болгон,

Нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14230/, Нарны зам-62, Юнион Бюлдинг, Б блок, хаягт байрлах, 6375405 регистрийн дугаартай “Тавантолгой төмөр зам” ХХК (цаашид “Захиалагч” гэх),

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, City Center 303 тоот хаягт бүртгэлтэй, 6012337 регистрийн дугаартай “Урбан девелопмент консалтинг групп” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх) (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлага, зааварчилгааны дагуу Богдхан төмөр замын Техник, Эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-г боловсруулах, мэргэжлийн байгууллагаар батлуулах, эдгээртэй холбогдох энэ гэрээнд заасан бусад ажил (цаашид “Ажил” гэх) ажлыг чанарын өндөр түвшинд холбогдох дүрэм, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэж, хүлээлгэж өгөх, Захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан ажлын хөлсийг төлөх хэлцэлийн нөхцөл, Талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон эдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гүйцэтгэгчийн боловсруулсан ТЭЗҮ нь мэргэжлийн байгууллагаар батлуулах шаардлагыг бүрэн хангасан, холбогдох тоо хэмжээ, мэдээллийн үнэн бодит, хөрөнгө оруулалтын мөнгөн дүн зэрэгт үндэслэж холбогдох тооцоо судалгааг хавсаргасан байх ба Хавсралт 1 буюу Ажлын даалгавар, Хавсралт 2 буюу Агуулгын хүрээнд гүйцэтгэнэ.

ХОЁР. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

- 2.1 Гэрээт ажлын хугацаа нь Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш ТЭЗҮ-г холбогдох мэргэжлийн байгууллагаар батлуулж, хүлээлгэн өгөх хүртэл байхаар харилцан тохиролцов.
- 2.2 Барилгын ажлын гүйцэтгэгч ТЭЗҮ-г өөрчлөх, сайжруулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тэрхүү засвар өөрчлөлтийг хийж холбогдох мэргэжлийн байгууллагаар батлуулах хүртэл сунгана.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1 Гэрээний нийт үнэ 2,224,399,130.00 /Хоёр тэрбум хоёр зуун хорин дөрвөн сая гурван зуун ерэн есөн мянга нэг зуун гучин төгрөг/ төгрөг байна. (НӨАТ орсон дүн)
- 3.2 Захиалагчаас ажлын хөлсийг Гүйцэтгэгчид гэрээгээр тохиролцсон ажлыг бүрэн гүйцэтгэж, ажлын үр дүнг хүлээлгэн өгснөөр төлнө.
- 3.3 Гүйцэтгэгчээс Энэхүү гэрээний Хавсралт 2 /Ажлын даалгавар/-т заасан гүйцэтгэлийн хувиар тухай бүр ажлын тайланг төлбөрийн нэхэмжлэхийн хамт Захиалагчид ирүүлж баталгаажуулна. Уг баталгаажуулалт нь 3.4-т заасан Захиалагчаас ажлын хөлсийг Гүйцэтгэгчид шилжүүлэх үндсэн баримт бичиг болно.
- 3.4 Гүйцэтгэгчээс энэхүү гэрээний дагуу ажлын үр дүнг бүрэн биелүүлж, ажлын даалгаврын биелэлт 100 хувь хүрч, холбогдох судалгааны тайлан, зураг төсөл иж бүрэн хангагдаж,

Захиалагч:

Гүйцэтгэгч:

ТЭЗҮ-ийг Зам, тээврийн хөгжлийн төв улсын үйлдвэрийн газар ТЭЗҮ-ийн техникийн зураг төслийг магадлаж, ЗТХЯ-ны ШУТЗ-өөр батлуулж, ТЭЗҮ-ийн зураг төслөөс шалтгаалсан зөрчил доголдол үүсээгүй, эсвэл үүссэн зөрчил доголдлыг засч тохируулсныг ажлын зураг гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Гэрээний нийт үнийн дүнгээр Гүйцэтгэгчид төлнө.

3.5 Төлбөрийг Гүйцэтгэгч талын Худалдаа хөгжлийн банкны 800008641 тоот дансанд Захиалагчаас шилжүүлнэ.

3.6 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1-д заасан ажил, түүнийг гүйцэтгэхтэй холбоотой гарах бусад ажлуудыг гэрээний 3.1-д заасан нийт үнэд багтаан хариуцна.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Захиалагч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 4.1.1 Гүйцэтгэгчээс гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор хугацаанд нь биелүүлэхийг шаардах эрхтэй;
 - 4.1.2 Гүйцэтгэгчийн ажил, түүний үр дүнд хяналт тавина;
 - 4.1.3 Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажлын явцын болон эцсийн тайлан гарсан үед эсхүл үйл ажиллагааны явцад шаардлагатай мэдээ, мэдээллийг авч хяналт тавьж ажиллана;
 - 4.1.4 Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор Захиалагч болон түүний ажилтан, зөвлөхүүд нь дараах эрх эдэлнэ;
 - 4.1.4.1 Техник, эдийн засгийн үндэслэл хийж байгаа Гүйцэтгэгчийн инженер, мэргэжилтэнд шаардлага тавих, зөвлөлдөх;
 - 4.1.4.2 Шаардлагатай тайлбар, мэдээлэл, баримт бичгийг Гүйцэтгэгчээс гаргуулан авах;
 - 4.1.4.3 Гүйцэтгэгчийн гаргасан Техник, эдийн засгийн үндэслэлд үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн мэргэшсэн шинжээч, инженерээр хянуулж дүгнэлт гаргуулах;
 - 4.1.4.4 Гүйцэтгэгчийг ажлын даалгаварт заасан ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавина.
 - 4.1.5 Ажлыг гүйцэтгэж дууссаны дараа Ажлын үр дүнг гүйцэтгэгчээс хүлээн авч, хөлсийг төлөх;
 - 4.1.6 Гүйцэтгэгч нь захиалгыг зөрчиж буруу, дутуу, чанар, стандартын шаардлага хангаагүй ажлыг тогтоосон хугацаанд засах, гүйцээн хийхийг шаардах, уг шаардлагыг биелүүлэх хүртэл санхүүжилтийг зогсоох эрх эдэлнэ;
 - 4.1.7 Захиалагч нь Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл болон төсөлтэй холбоотой бусад шалтгаанаар шаардлага, мэдэгдэл хүргүүлж болно.
 - 4.1.8 Гүйцэтгэгчийн хийсэн ТЭЗҮ нь холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан журам, стандартыг баримтлаагүй эсвэл эрх бүхий байгууллага шаардлага хангаагүйн улмаас батлаагүй эсхүл хэмжээс болон тооцоолт нь алдаатай, доголдолтой бол гэрээг цуцлах эрх эдэлнэ;
 - 4.1.9 Барилгын ажлын явцад болон төрийн холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулахад өөрчлөлт оруулах шаардлага үүссэн тохиолдолд үнэ төлбөргүй гүйцэтгүүлэх;

Захиалагч:

Гүйцэтгэгч:

- 4.1.10 Гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа зохих ёсоор биелүүлэх;
- 4.1.11 Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу үйлчилгээний үр дүнд ямар нэг доголдол байвал Захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажлын үр дүнг хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гаргах эрхтэй;
- 4.1.12 Гэрээний 3.2 дахь хэсэгт заасан төлбөрийг Гэрээнд заасан хугацаанд төлөх;
- 4.1.13 Захиалагч нь Ажил гүйцэтгэх үед шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх;
- 4.1.14 Гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу буруу зааварчилгааг өөрчлөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах;
- 4.1.15 Гэрээгээр тохиролцсон ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчинг тогтмол ажиллуулахыг шаардах;
- 4.1.16 Хууль болон гэрээнд заасан бусад үүргийг хүлээж, эрх эдлэнэ.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Гүйцэтгэгч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

- 5.1.1 Захиалагчийн шаардлагын дагуу ТЭЗҮ-г Монгол улсын хэмжээнд болон олон улсад мөрдөж буй стандартын дагуу орчин үеийн шаардлагад нийцсэн технологиор, чанарын өндөр түвшинд, гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ. Ажлыг хийж гүйцэтгэхдээ дараах Хавсралтад заасныг баримтлана.
- 5.1.1.1 Хавсралт 1 — Агуулгын хүрээ
- 5.1.1.2 Хавсралт 2 — Ажлын даалгавар
- 5.1.1.3 Хавсралт 3 — Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө /календарчилсан/
- 5.1.1.4 Хавсралт 4 — Голлох инженер, мэргэжилтнүүдийн мэдээлэл
- 5.1.1.5 Хавсралт 5 — Зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийн баримт бичиг, зөвшөөрлүүд
- 5.1.2 Гүйцэтгэгчийн ажлын үр дүн буруу, дутуу болсон эсхүл хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, Захиалгчийн өгсөн ажлын даалгавар болон төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчсөн нь ажлын үр дүнг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засаж доголдлыг арилгах, үүнээс үүдэж Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй;
- 5.1.3 Гүйцэтгэгч нь ажлыг ажиллах хүчээр гүйцэтгэх бөгөөд ажлын шаардлага, Захиалагчийн шаардсанаар ажиллах хүчийг нэмэгдүүлэх байдлаар ажлыг гүйцэтгэнэ.
- 5.1.4 Гүйцэтгэгч нь үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна;
- 5.1.5 Гүйцэтгэгч нь ТЭЗҮ-г боловсруулж дуусмагц төрийн эрх бүхий байгууллагаар батлуулан холбогдох судалгааны хамт цаасан болон цахим байдлаар Захиалагчид ирүүлэх үүрэгтэй;
- 5.1.6 Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор хугацаанд нь биелүүлэхийг шаардах эрхтэй;
- 5.1.7 Гүйцэтгэгч нь Ажил гүйцэтгэхэд шаардлагатай Захиалагчаас авч буй мэдээлэл, баримт, материалыг ашиглахдаа үнэн зөв, бүрэн гүйцэт, холбогдох стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж, хянах;

Захиалагч:

Гүйцэтгэгч:

- 5.1.8 Ажил гүйцэтгэх явцад ашигласан Захиалагчаас хүлээн авсан баримт, материалыг Ажлын үр дүнг хүлээлгэн өгөхөд хамт буцаан өгөх үүрэгтэй;
- 5.1.9 Гэрээгээр тохиролцсоны дагуу гүйцэтгэсэн ажлын хөлсийг шаардах эрхтэй;
- 5.1.10 Гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар тайлан мэдээг Захиалагчид тогтмол ирүүлэх бөгөөд Захиалагч талтай тогтмол хамтран ажиллаж, ажлын зааварчилгаа, чиглэл авч ажиллана;
- 5.1.11 Хууль болон гэрээнд заасан бусад үүргийг хүлээж, эрх эдлэнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ, ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1 Гүйцэтгэгч гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаа, нөхцлийн дагуу гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэж өгснөөр Захиалагч талаас гэрээний төлбөрийг бүрэн төлж гэрээг дуусгавар болгоно.
- 6.2 Энэхүү гэрээнд заасны дагуу ажил хүлээлцэх үед Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол илэрвэл Гүйцэтгэгч доголдлыг өөрийн зардлаар арилгах үүрэг хүлээнэ. Доголдол гэдэгт Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан стандарт журмыг баримтлаагүй эсвэл тоо хэмжээ, хэмжээс, тооцоолол болон хөрөнгө оруулалтын дүн зэрэг нь алдаатай, шаардлагад нийцээгүй, дутуу гүйцэтгэх зэргийг хамруулан ойлгоно.
- 6.3 Ажлын доголдлыг арилгах талаар Гүйцэтгэгч тогтоосон хугацаанд ямар нэг арга хэмжээ аваагүй бол Захиалагч уг доголдлыг арилгаж, түүнтэй холбогдсон зардал болон хохирлоо Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлнэ.
- 6.4 Гүйцэтгэгч нь ажлыг тогтоосон хугацаанаас хожимдуулах, ажлыг дутуу, чанаргүй хийснээс үүдэн гарах аливаа эрсдэл болон хохирлыг дангаар хариуцаж, бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 6.5 Талууд хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хугацаа хэтрүүлсэн хоног тутамд нөгөө талдаа алданги төлнө.
- 6.6 Техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаагаар тодорхойлж, магадлан батлагдсан газар шорооны ба хонгилын ажлын тоо хэмжээ барилга угсралтын шатанд 5%-аас илүү дүнгээр хэлбэлзэх тохиолдолд илүү гарсан ажлын зардлын 10%-тай дүйцэх хэмжээний нөхөн төлбөрийг Гүйцэтгэгч Захиалагчид төлнө.

ДОЛОО. НУУЦ ХАДГАЛАХ

- 7.1 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бус замаар олж мэдсэн төрийн, байгууллага, хувь хүний нууцад хамаарах (техник, санхүү, бизнесийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх, ашиглахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 7.2 Гүйцэтгэгч нь зам барилгын ажлын тоо хэмжээ, нэгдсэн төсөв, төсөвт өртгийн хэмжээг нууцлан хадгалах бусдад мэдээлэхгүй байх үүрэгтэй.
- 7.3 Энэхүү гэрээний 7.1-д заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцна.

НАЙМ. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

- 8.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас (тухайлбал онц болон дайны байдал тогтох, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаялт, цар тахал, гоц халдварт өвчин) зэрэг нөхцөл байдал нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нь нотлогдсон бол Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэглэн чөлөөлөгдөнө.

Захиалагч:

Гүйцэтгэгч:

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

8.2. Талуудын аль нэг нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Үүрэг гүйцэтгэгч нь дээрх нөхцөл байдал болон түүний үр дагавар арилмагц гүйцэтгээгүй үүргээ нэн даруй бодитойгоор биелүүлнэ. Үүнтэй холбоотойгоор гэрээний хугацаанд өөрчлөлт орохоор бол талууд харилцан тохиролцоно.

ЕС. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ

9.1. Ажил хүлээлгэн өгсөн актанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, хугацаа, ажлыг шалгасан үр дүнг тусгах ба ажил хийхэд ашигласан судалгааны материал болон холбогдох баримт бичгүүдийг хүлээлгэн өгнө.

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1. Энэхүү гэрээг зөрчсөнөөс болон түүнийг хэрэглэх, тайлбарлах, хүчинтэй хугацааг тогтоох, сунгах, цуцлахтай холбогдсон аливаа маргаан зөрчилдөөн, гомдлын шаардлагыг талууд эвийн журмаар зөвлөлдөн шийдвэрлэнэ.
- 10.2. Гэрээний гүйцэтгэлтэй холбоотой аливаа мэдээлэл, мэдэгдлийг бичгээр үйлдэн энэхүү гэрээнд заасан хаяг, утас, албан бичгээр болон цахим шуудангаар илгээх эсхүл биечлэн мэдэгдэх хэлбэрээр солилцоно. Биечлэн мэдэгдэх мэдэгдлийг энэхүү гэрээнд гарын үсэг зурсан этгээдүүдэд мэдэгдэж баталгаажуулсан байна.
- 10.3. Гэрээний хэрэгжилттэй холбоотойгоор маргаан гарвал талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба боломжгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАННЭГ. БУСАД

- 11.1. Гэрээ нь талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээ дарснаар хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 /хоёр/ хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 11.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд зөвхөн бичгээр оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах мэдэгдэл болон гэрээтэй холбоотой аль нэг талдаа тавьж буй санал, санаачилга, мэдэгдэл, хүсэлтийг зөвхөн бичгээр нөгөө талдаа илэрхийлнэ.
- 11.4. Гэрээ нь гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно
- 11.5. Гэрээний талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүйгээс гэрээг цаашид үргэлжлүүлэх боломжгүйд хүрвэл нөгөө тал гэрээг цуцлах санал гаргаж болно. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 11.6. Гэрээг цуцлахтай холбогдон гарсан хохирлыг гэрээний үүргээ зөрчсөн тал нь барагдуулах үүрэгтэй.
- 11.7. Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Захиалагч:

Гүйцэтгэгч:


ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч талыг төлөөлж:

6375405 СБА2198
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


...../Н.УДААНЖАРГАЛ/


Гүйцэтгэгч талыг төлөөлж:

6375405 СБА2198
“УРБАН ДЕВЕЛОПМЕНТ КОНСАЛТИНГ
ГРУПП” ХХК

ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ...../

Д.ЭНХМАНЛАЙ/

Захиалагч:



Гүйцэтгэгч:

